



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 04 сарын 13 ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

ТУШААХ НЬ:

1. Гэгээрлийн сайдын 1998 оны 194 дүгээр тушаалаар АНУ-ын Денвер хотын Колорадогийн их сургуульд магистрантурт суралцаж буй Ядмаа овогтой Гантөмөрийн сурлагын амжилт болон мэдээллийн систем, бизнесийн удирдлагаар давхар магистрын зэрэг олгох сургалтанд хамрагдаж байгааг харгалзан түүний сургалтын хугацааг 1.5 жилээр сунгасугай.

2. 1998 оны шилдэг оюутнаар шалгарсан Төмөрийн Батзаяаг АНУ-ын Өмнөт Дакотагийн их сургуулийн магистрантурт химийн технологийн мэргэжлээр 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

3. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу дээрхи хүмүүстэй гэрээ байгуулж холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхжаргал/-д тус тус даалгасугай.



САЙД

А. БАТТӨР